



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Насан туршийн боловсролын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2023/189/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn  Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал .....	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4.5.1 Завсрын аудитын талаар .....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
ТАГ	Төрийн аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

*2023.02.23* № *2/23*

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г \_\_\_\_\_ Г

Г БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ  
НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН  
ТӨВИЙН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
Д.АМГАЛАН ТАНАА

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын газрын дэргэдэх насан туршийн боловсролын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын газрын дэргэдэх насан туршийн боловсролын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

• 005020168

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,227,154.00</u></b>	<b><u>3,739,763.25</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	1,794,016.25
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	1,794,016.25
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	1,794,016.25
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,794,016.25
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	554.00	297,347.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	554.00	297,347.00
3351	Байгууллагаас авах авлага	554.00	297,347.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,226,600.00	1,648,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,226,600.00	1,648,400.00
35410	Бичиг хэргийн материал	65,000.00	263,500.00
35420	Аж ахуйн материал	1,161,600.00	1,384,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>27,189,893.54</u></b>	<b><u>22,550,364.12</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	27,189,893.54	22,550,364.12
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	26,828,360.20	22,263,630.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,734,258.00	46,555,658.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,455,129.70	-28,019,917.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,926,453.00	13,724,353.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,739,321.10	-10,358,562.56
39217	Ном	362,100.00	362,100.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	361,533.34	286,733.38
39301	Программ хангамж	374,000.00	374,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-12,466.66	-87,266.62
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>28,417,047.54</u></b>	<b><u>26,290,127.37</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>91,779.59</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	91,779.59
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	91,779.59
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	91,779.59
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>28,417,047.54</u></b>	<b><u>26,198,347.78</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	28,417,047.54	26,198,347.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	14,448,360.20	14,448,360.20
51101	Өмч: - төрийн	14,448,360.20	14,448,360.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	13,968,687.34	11,749,987.58
51220	Тайлант үеийн үр дүн	13,968,687.34	11,749,987.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>28,417,047.54</u></b>	<b><u>26,290,127.37</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>60,412,800.00</b>	<b>142,990,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,000,000.00</b>	<b>9,141,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,000,000.00	9,141,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,000,000.00	6,821,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,000,000.00	6,821,400.00
120009	Бусад орлого	00.00	2,320,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>54,412,800.00</b>	<b>133,848,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	54,412,800.00	133,848,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	54,412,800.00	133,848,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>46,444,112.66</b>	<b>145,208,699.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>46,444,112.66</b>	<b>145,208,699.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	46,444,112.66	145,208,699.76
<b>2101</b>	<b>Цалин хөлө болон нэмэгдэл урамшил</b>	32,226,757.00	112,590,690.31
210101	Үндсэн цалин	32,226,757.00	97,973,418.93
210102	Нэмэгдэл	00.00	10,996,201.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,306,760.38
210104	Урамшуулал	00.00	314,310.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,999,802.00	13,693,880.03
210201	Тэтгэврийн даатгал	2,999,802.00	9,578,119.26
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,076,360.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	861,088.19
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	194,909.03
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,983,403.30
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,701,088.00	2,268,800.00
210401	Бичиг хэрэг	366,500.00	1,428,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,288,288.00	745,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,046,300.00	95,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	701,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	701,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,516,465.66	15,953,829.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,503,999.00	1,643,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,051,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,466.66	12,258,829.42
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>13,968,687.34</b>	<b>-2,218,699.76</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>54,412,800.00</b>	<b>136,168,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>2,320,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	2,320,000.00
120009	Бусад орлого	00.00	2,320,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>54,412,800.00</b>	<b>133,848,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	54,412,800.00	133,848,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	54,412,800.00	133,848,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>47,658,800.00</b>	<b>134,374,583.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>47,658,800.00</b>	<b>134,374,583.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>47,658,800.00</b>	<b>134,374,583.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	30,172,728.00	112,765,687.76
210101	Үндсэн цалин	30,172,728.00	98,473,750.02
210102	Нэмэгдэл	00.00	9,525,229.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	2,818,341.74
210104	Урамшуулал	00.00	1,948,367.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,054,385.00	13,723,895.99
210201	Тэтгэврийн даатгал	5,054,385.00	9,332,300.79
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,097,900.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	878,300.26
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	219,498.46
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,195,895.65
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	2,320,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,320,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,431,687.00	5,565,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,431,687.00	3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	00.00	2,565,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6,754,000.00</b>	<b>1,794,016.25</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,754,000.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,754,000.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	6,754,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,754,000.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-6,754,000.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	1,794,016.25
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	1,794,016.25

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,448,360.20	13,968,687.34	28,417,047.54
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,448,360.20	13,968,687.34	28,417,047.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,448,360.20	13,968,687.34	28,417,047.54
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,218,699.76	-2,218,699.76
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,448,360.20	11,749,987.58	26,198,347.78

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	133,848,600.00	132,054,583.75	1,794,016.25	99%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	133,848,600.00	132,054,583.75	1,794,016.25	99%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	133,848,600.00	132,054,583.75	1,794,016.25	99%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	114,029,900.00	112,765,687.76	1,264,212.24	99%
210101	Үндсэн цалин	110,808,800.00	98,473,750.02	12,335,049.98	89%
210102	Нэмэгдэл	1,339,900.00	9,525,229.00	(8,185,329.00)	711%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	2,818,341.74	(2,818,341.74)	0%
210104	Урамшуулал	1,881,200.00	1,948,367.00	(67,167.00)	104%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,253,700.00	13,723,895.99	529,804.01	96%
210201	Тэтгэврийн даатгал	9,692,500.00	9,332,300.79	360,199.21	96%
210202	Тэтгэмжийн даатгал	1,140,300.00	1,097,900.83	42,399.17	96%
210203	ҮОМШӨ-ний даатгал	912,300.00	878,300.26	33,999.74	96%
210204	Ажилгүйдлийн даатгал	228,000.00	219,498.46	8,501.54	96%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,280,600.00	2,195,895.65	84,704.35	96%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5565000.00	5565000.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,565,000.00	2,565,000.00	-	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	133,848,600.00	133,848,600.00	-	100%
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	133,848,600.00	133,848,600.00	-	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	133,848,600.00	133,848,600.00	-	100%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,794,016.25		
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	0.00	100%

610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	09.00	09.00	-	100%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	-	0%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Насан туршийн боловсролын төвийн 2022 оны зорилгыг “Нийгмийн бүхий л орчин, цаг хугацаанд иргэд өөрийн хэрэгцээнд нийцүүлэн, боловсрол эзэмших боломжийг хүн бүрд адил тэгш олгоход шаардагдах боловсролын агуулга, арга зүйг тодорхойлох, хүний нөөц болон материаллаг орчныг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангаснаар насан туршийн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэхэд оршино.” гэж тодорхойлжээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаанд дараах бодлогын баримт бичгийн чиглэл болгон үйл ажиллагаагаа явуулсан. Үүнд:*

“Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр” засгийн газрын 2018 оны 209 дүгээр тогтоол

“Насан туршийн боловсрол хөтөлбөр” БСШУ-ны сайдын 2019 оны А/756

“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2023” БШУЯ-ны сайдын 2020 оны А/96 дугаар тушаал

“Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө 2021-2023” БШУ-ны сайдын 2021 оны А/190 дүгээр тушаал

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоол 2

“Боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр” БШУ-ы сайдын 2021 оны А/88

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Боловсрол шинжлэх ухааны газар дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Насан туршийн боловсролын төвийн 2022 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлэн, аккруэл сууриар хөтөлж, тусгай зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлд ашиглаж байна. Тус баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Насан туршийн боловсролын төвийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,701.6 мянган төгрөгөөр буюу 0.97 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.0	1,794.0	1,794.0
АВЛАГА	00.6	297.3	296.8
БАРАА МАТЕРИАЛ	1,226.6	1,648.4	421.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,396.8	61,016.1	7,619.3
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-26,206.9	-38,465.7	-12,258.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,417.0	26,290.1	-2,126.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.0	91.8	91.8
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,417.0	26,198.3	-2,218.7
Засгийн газрын хувь оролцоо	28,417.0	26,198.3	-2,218.7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,417.0	26,290.1	-2,126.9

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,794.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлын хэмнэлтийн зарцуулаагүй үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 296.8 мянган төгрөгөөр өссөн нь 12 сард 300.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгоод суутган тооцоогүйгээс үүссэн авлагатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,648.4 мянган төгрөг болж 421.8 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 195.5 мянга, аж ахуйн материал 223.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 61,016.1 мянган төгрөг болж 7,619.2- мянган төгрөгөөр өссөн нь аймгийн БШУГ-ийн 2022.12.26-ны өдрийн 516 дугаар албан бичгээр

6,821.4 мянган төгрөгийн өртөгтэй зөөврийн компьютерыг үнэ төлбөргүй шилжин ирж, төсвийн хөрөнгөөр 797.9 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авснаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр 91.8 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын 91.8 мянган төгрөгийн өглөгтэй гарснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 26,198.3 мянган төгрөг болж 2,218.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 181,427.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулахаар төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 47,578.7 мянган төгрөгөөр бууруулж, 133,848.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 133,848.6 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс 133,848.6 төгрөгөөр санхүүжилт авсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 132,054.6 мянган төгрөг буюу 98.7 хувь зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71806- Насан туршийн болон албан бус боловсрол	133,848.6	132,054.6	1,794.0	99%
АРГА ХЭМЖЭЭ 81834- Боловсролын стандарт сургалт	111,382.5	110,345.6	1,036.9	99%
АРГА ХЭМЖЭЭ 81135 -Сургалтын хэвийн үйл ажиллагаа	22,466.1	21,709.0	757.1	97%

Эх сурвалж: 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Насан туршийн боловсролын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Насан туршийн боловсролын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.09.09-ны өдрийн 27 дугаар албан бичгээр, 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, аудитад шаардагдах баримт материалыг 2023.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 145,208.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,178.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 1,524.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус салбар нь 133,484.6 мянган төгрөгийн батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан ба бичиг хэргийн материал, аж ахуйн материалын зардлыг батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулсан. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны нэгдсэн системд мэдээлэх 5,0 сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад орлого, зарлагын гүйлгээ байхгүй ба 2022 оны 10 шилэн дансны сайтад нэвтрэх эрх нээлгэж дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн мэдээллийг нөхөж мэдээлсэн болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудит хамрагдаагүй болно.

### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.